



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 04 сарын 16 өдөр

Дугаар 19/04

Улаанбаатар хот

### Үндэсний хорооны ажиллах журмыг шинэчлэх тухай

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2017 оны 51 дүгээр захирамжаар батлагдсан “Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Ч.Гантулгад даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙД, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ  
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ

Үндэсний хорооны 2019 оны 04 дүгээр  
сарын 16 өдрийн 19 дугаар  
тогтоолын хавсралт



## ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Агаарын тухай хууль, Усны тухай хууль, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Гамшигийн тухай хууль, "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр" зэрэг хууль тогтоомжид заасан агаар, орчны бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороо (цаашид "Үндэсний хороо" гэх)-ны үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Үндэсний хороо нь үйл ажиллагаандаа орчны бохирдлыг бууруулахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн Газрын шийдвэр, энэхүү журмыг удирдлага болгоно.

### Хоёр.Үндэсний хорооны чиг үүрэг

2.1. Үндэсний хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагуудын чиг үүрэг, ажлын заагийг тогтоож, хариуцсан ажлын хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.2 Орчны бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжих, урамшуулах, орчны төлөв байдлын тухай нийтэд мэдээлэх ухаалаг тогтолцоог бий болгох талаар шаардлагатай арга хэмжээг авах;

2.1.3 Орчны бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажлын биелэлтийн талаар холбогдох албан тушаалтны сонсгол, тайланг хэлэлцэх, шаардлагатай мэдээ тайлан гаргуулж авах.

### Гурав. Үндэсний хорооны хуралдааны зохион байгуулалт

3.1 Үндэсний хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Үндэсний хорооны хуралдаанд дарга, гишүүд таслах эрхтэйгээр оролцох ба биеэр оролцоогүй тохиолдолд хэлтсийн даргаас дээш албан тушаалтан оролцуулна. Хуралдааныг гишүүдийн ердийн олонх нь оролцсоноор хүчинтэйд тооцно.

3.2 Үндэсний хорооны ээлжит хуралдааныг улирал тутамд зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Үндэсний хорооны даргын санаачилгаар ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

3.3 Хуралдааныг Үндэсний хорооны дарга даргална. Үндэсний хорооны даргын эзгүйд хурлыг нарийн бичгийн дарга орлоно.

3.4 Үндэсний хорооны гишүүн ээлжит хуралдаанаас 14 хоногийн өмнө холбогдох тайлан, мэдээг ирүүлнэ. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдох материалыг

хуралдаан товлогдсон өдрөөс 3 хоногийн өмнө Үндэсний хорооны гишүүдэд хүргүүлсэн байна.

3.5 Үндэсний хорооны гишүүн хуралдаанд биечлэн оролцох боломжгүй тохиолдолд хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан саналаа бичгээр ирүүлж болно. Энэ нөхцөлд гишүүнийг хуралд ирснээр тооцно.

3.6 Үндэсний хороо нь үйл ажиллагаагаа улирал, хагас жил, жилийн хугацаагаар төлөвлөж, тайлангаа хагас, бүтэн жилээр хэлэлцэж дүгнэнэ.

3.7 Үндэсний хорооны нарийн бичгийн дарга нь Ажлын албаны дарга байна.

### **Дөрөв. Үндэсний хорооны хуралдааны шийдвэр**

4.1 Үндэсний хороо нь хууль тогтоомж болон энэхүү журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж, хуралдаанд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналаар шийдвэрлэх бөгөөд шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

4.2 Үндэсний хорооны хуралдаанаас гарах шийдвэр нь хууль тогтоомжид нийцсэн байна.

4.3 Үндэсний хорооны хуралдааны тэмдэглэлд хорооны дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

4.4 Үндэсний хорооны гишүүд нь хуралдаанаас гарсан шийдвэрт хамтын хариуцлага хүлээнэ.

4.5 Үндэсний хорооны гишүүд тогтоолоор хэрэгжиж буй ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн хуваарь, үйл ажиллагаа тасалдахгүй байхад анхаарч ажиллана.

4.6 Үндэсний хорооны шийдвэрийг холбогдох байгууллага, хариуцсан албан тушаалтан биелүүлэх үүрэгтэй бөгөөд явц, үр дүнг тогтоосон хугацаанд тогтмол тайлагнана.

### **Тав. Ажлын алба**

5.1 Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагаа нь Үндэсний хорооны даргын баталсан "Ажлын албаны дотоод журам"-аар зохицуулагдана.

5.2 Ажлын алба нь:

- "Бодлого төлөвлөлтийн",
- "Захиргаа, хамтын ажиллагааны"
- "Судалгаа, инноваци, орчны чанарын",
- "Мэдээлэл, сургалт, олон нийттэй харилцах" чиглэлийн нэгжүүдтэй байна.

5.3 Ажлын албаны даргыг Үндэсний хорооны дарга томилж, чөлөөлнө.

5.4 Ажлын албаны нэгжийн дарга, ажилтнуудыг Ажлын албаны даргын санал болгосноор Үндэсний хорооны дарга томилж, чөлөөлнө.

5.5 Ажлын албаны дарга, нэгжийн дарга, ажлын албаны ажилтнууд нь төрийн үйлчилгээний албан хаагч байна.

5.6 Ажлын албаны орон тооны дээд хязгаар 30 хүртэл байх бөгөөд үйл ажиллагааны зардлыг нь Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсвийн багцын Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлнэ.

5.7 Ажлын алба нь доорх эрх хэрэгжүүлж, үүрэг хүлээнэ. Үүнд:

5.7.1 Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр улсын хэмжээнд баримтлах чиглэл, холбогдолтой хууль эрхзүйн баримт бичгийг боловсруулах, санал өгөх, ажлын хэсэгт орж ажиллах, комисс байгуулан ажиллах, шаардлагатай зөвлөгөөгөөр хангах

5.7.2 Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэл, үүрэг, Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу холбогдох яамд, газар, мэргэжилтнээс мэдээ мэдээлэл, тайлан гаргуулах, нэгтгэх, салбар хоорондын уялдааг сайжруулах, дэд ажлын хэсгүүдэд чиглэл өгөх, үндэсний хорооны гишүүдийг мэдээллээр хангах;

5.7.3. Хорооны хуралдааны тэмдэглэлд үндэслэн өгсөн үүрэг, даалгаврыг нийслэл, аймаг орон нутагт биелүүлэх, зохион байгуулах, эрчимжүүлэх;

5.7.4. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр олон нийтийн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, компанит ажлыг зохион байгуулах, чиглүүлэх

5.7.5. Агаар, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр нийслэл, орон нутгийн хариуцсан албан тушаалтанд мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, сургалт зохион байгуулах, тайлан гаргуулах

5.7.6. Орчны төлөв байдлын болон эх үүсвэрийн хяналт шинжилгээний мэдээ, мэдээлэлд хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх;

5.7.7. Үндэсний хорооны ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах, гарсан шийдвэрийг баримтжуулах, үйл ажиллагааны өдөр тутмын болон улирал, жилийн тайланг боловсруулах, нэгтгэх ажлыг удирдан зохион байгуулах;

5.7.8. Олон улсын төсөл хөтөлбөр, байгууллагатай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хэрэгжүүлэх;

5.7.9. Үндэсний хорооны Ажлын албаны өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах